

Golomt Capital®

# Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.04.25

*Дотоодын зах зээл  
Олон улсын зах зээл*

## ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 4 сарын 25


Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,065.97	0.616%	7.616%	7.577%

### Товч дүгнэлт:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.616 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаар Төв банкнаас интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаа тул ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна.

### Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 148.7 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкууд 5 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн форвард хэлцэл байгуулах саналыг хоёр удаа ирүүлсэн ч Монголбанк ирүүлсэн саналыг биелүүлээгүй байна.



### Гадаад худалдаа:

2022 оны 3 сард Монгол Улсын гадаад худалдаа 109 сая ам.долларын ашигтай гарлаа. Ингэснээр 2022 оны эхний 3 сард цэвэр экспорт 251.3 сая ам.доллар хүрч бараа эргэлт 1.41 тэрбум ам.долларт хүрсэн байна. Гадаад худалдааны тэнцэл эерэг гарах нь тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг чангарах нөхцөлийг бүрдүүлдэг.



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 4-р сарын 25

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	101.19	0.44%	2.59%	3.98%
EURUSD	1.0801	0.21%	-1.62%	-10.59%
USDCNY	6.5002	2.17%	2.13%	0.26%
USDRUB	75.45	-5.39%	-21.41%	0.59%
USDJPY	128.71	1.41%	5.49%	19.13%
AUDUSD	0.7204	-0.6%	1.12%	9.99%

## DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэргийн чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Өнгөрсөн долоо хоногийн пүрэв гарагт АНУ-ын ХНС-ийн тэргүүн Jerome Powell мэдэгдэл хийхдээ, инфляцын түвшинг бууруулахын тулд бодлогын хүүг эрчимтэй нэмэгдүүлэх нь зүйтэй бөгөөд 5 сарын Холбооны нөөцийн сангийн нээлттэй захын хурлаар бодлогын хүүг 50 нэгжээр нэмэгдүүлэх эсэх талаар хэлэлцэнэ хэмээлээ.
- Энэ долоо хоногийн пүрэв гарагт АНУ-ын 2022 оны 1 дүгээр улирлын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн тоон мэдээ гарах бөгөөд арилжаачид АНУ-ын эдийн засаг хэр өсөлт үзүүлснийг чих тавин хүлээж байна.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.